



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 246

Улаанбаатар хот

Төсвийн байгууллагыг өөрчлөн байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 10.1.10, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 10.1.5, 19.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт”-ийг “Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн” эрдэм шинжилгээний байгууллага болгож өөрчлөн зохион байгуулсугай.

2.Өөрчлөн зохион байгуулагдсан төсөвт байгууллагын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг холбогдох хууль тогтоомж, батлагдсан төсөвтөө багтаан шинэчлэн батлахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төсвийн байгууллагыг өөрчлөн зохион байгуулах тухай” Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 251 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

117A1206 9023100394 5498449

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Л.ЭНХ-АМГАЛАН